



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 10

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Сайнцагаан сумын Хоёрдугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 86,675,992.29 (наян зургаан сая зургаан зуун далан таван мянга есөн зуун ерэн хоёр төгрөг хорин есөн мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй барилга байгууламжийг акталж, данснаас хасах, акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Хоёрдугаар цэцэрлэгийн эрхлэгч (М.Туул) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг Орон нутгийн өмчийн газар, сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, илүү гарсан хуучин материалыг худалдах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

430322027

Сайнцагаан сумын Хоёрдугаар цэцэрлэгийн барилга байгууламжийн мэдээлэл



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн
10-р... Голлоолын хавсралт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагд сан элгдэл	Үлдэгдэл өртөг
1	Цэцэрлэгийн барилга	1964.01.01	ш	1	86,675,992.29	86,675,992.29	-
Нийт хөрөнгийн дүн					86,675,992.29 (наян зургаан сая зургаан зуун дагдан таван мянга есөн зуун ерэн хоёр төгрөг хорин есөн мөнгө)		



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум

Утас: 70593232, 70593399

e-mail: umch@dundgovi.gov.mn

2022.02.17 № 34

танай _____ -ны № _____ -т

**САЙНЦАГААН СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГТ**

Танай ирүүлсэн хүсэлтийн дагуу “Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” аймгийн ИТХ-ын 2022 оны 10 дугаар тогтоол гарсан тул тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлнэ үү.

Барилгыг буулгахдаа аймгийн Орон нутгийн өмчийн газар, сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг байлцуулан, тэдгээрийн хяналт дор буулгахыг анхааруулъя.

Хавсралт хуудас

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ _____ ЖАНТУЛГА

